



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар  
хот


## Даатгалын босго үзүүлэлт шинэчлэн тогтоох тухай

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 7.1, 7.3, 7.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Малын индексжүүлсэн даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор 2021-2023 онд мөрдөх “Малын индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлт”-ийг хавсралт ёсоор шинэчлэн тогтоож, 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлсүгэй.

2. Шинэчлэн тогтоосон даатгалын босго үзүүлэлтийг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд зөвлөсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Даатгалын босго үзүүлэлт тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 33 дугаар тогтоолыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

УХА0064

У.ХҮРЭЛСҮХ

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2020 оны 219 дүгээр  
тогтоолын хавсралт

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН БОСГО ҮЗҮҮЛЭЛТ

№	Аймаг/Хот	Сум/Дүүрэг	Нэгдүгээр босго үзүүлэлт	Хоёрдугаар босго үзүүлэлт
1.	Архангай	Бүх сум	5%	30%
2.	Баян-Өлгий	Бүх сум	5%	25%
3.	Баянхонгор	Бүх сум	6%	30%
4.	Булган	Бүх сум	5%	25%
5.	Говь-Алтай	Бүх сум	6%	30%
6.	Говьсүмбэр	Бүх сум	6%	25%
7.	Дархан-Уул	Бүх сум	6%	25%
8.	Дорноговь	Бүх сум	5%	25%
9.	Дорнод	Бүх сум	6%	25%
10.	Дундговь	Бүх сум	6%	30%
11.	Завхан	Бүх сум	6%	30%
12.	Орхон	Бүх сум	5%	30%
13.	Өвөрхангай	Бүх сум	6%	25%
14.	Өмнөговь	Бүх сум	5%	30%
15.	Сүхбаатар	Бүх сум	5%	30%
16.	Сэлэнгэ	Бүх сум	5%	25%
17.	Төв	Бүх сум	5%	25%
18.	Увс	Бүх сум	6%	30%
19.	Ховд	Бүх сум	5%	25%
20.	Хөвсгөл	Бүх сум	5%	30%
21.	Хэнтий	Бүх сум	5%	30%
22.	Улаанбаатар	Бүх дүүрэг	5%	30%